

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ БОЛОН ӨЛЗИЙТ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БААТАР ОВОГТОЙ ХОРЛООГИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

ЗОРИЛТ: Орон нутгаа хөгжүүлэхэд Хүний хөгжил, Гэр бүлд суурилсан өв соёлыг дээдэлсэн, Иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжсэн, Үйлдвэрлэл хөгжүүлсэн, Эко орчин бүрдүүлэх зорилт тавин ажиллана.


ЗОРИЛГО: Зорилтод хүрэхийн тулд дараах 4 зорилго хэрэгжүүлнэ.

1. Хүний хөгжил, Гэр бүлд суурилсан уламжлалт өв соёлыг дээдэлсэн **“Их говийнхон буюу Өлзийтийн өнгө”** төрхөөрөө бахархах үзэл төлөвшүүлж, өв соёлын дархлааг нь дэмжиж төрлөх нутгаа алдаршуулна.
2. Иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжиж ажиллах хүрээнд Иргэн бүрийг хамтын оролцоонд суралцуулах тэдэнд, чиглүүлэгч нь байх болно
3. Үйлдвэрлэл хөгжүүлэх ажлын хүрээнд Өлзийт сумын нутгийн брэнд үйлдвэрлэл, Аялал жуулчлалын үйлчилгээг ахисан түвшинд хүргэнэ.
4. Эко орчин бүрдүүлэх ажлын хүрээнд Өлзийт сумын иргэн бүр амар тайван орчин ажиллаж амьдрах нөхцөл бүрдүүлнэ.

НЭГ. Хүний хөгжил, Гэр бүлд суурилсан уламжлалт өв соёлыг дээдэлсэн **“Их говийнхон буюу Өлзийтийн өнгө”** төрхөөрөө бахархах үзэл Төлөвшүүлж, өв соёлын дархлааг нь дэмжиж төрөлх нутгаа алдаршуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.1. Говь нутгийн хатуу ширүүн цаг уурт дасан зохицсон өв соёл, дадал, сэтгэлгээнд тулгуурласан, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан, Говийн малчдаар бахархал болгосон аймгийн хэмжээний тэргүүлэх сум болгоход ард иргэдээ дайчлан чиглүүлж тодорхой амжилтад хүрнэ. */Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/*
- 1.2. Өлзийт суманд өмнөх онуудад хэрэгжүүлж ирсэн УГИЙН БИЧИГ хэвлэмэл дэвтрийг баяжуулан хөтлөх, ураг овгуудын баяр наадмыг хийх уламжлалт зан үйлийг түгээн дэлгэрүүлэх хэвшүүлэхэд ард иргэдэд ухуулга сурталчилгааг тогтмол хийж түвшнийг ахиулна. */Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/*
- 1.3. Жил бүр уламжлал болгон явуулдаг “Тэнгэрлэг гэр бүл” шалгаруулалтыг сумын хэмжээнд чанарын өндөр түвшинд явуулах, гэр бүлүүдийг өргөнөөр оролцуулах, хамрах хүрээг тэлэхэд чиглүүлсэн ухуулга сурталчилгаа мэдээ мэдээллийг сайжруулахад анхаарч ажиллана. */Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/*




- 1.4. Өлзийт сумын Залуу өсвөр үед морин хуур, уртын дууны өвийг өвлүүлэн үлдээх, хөгжүүлэх ялангуяа гадаад, дотоодын жуулчдад үндэсний өв соёл, нүүдлийн ахуйтай холбож СОЁЛЫН ҮНЭТ ӨВ болох ХАДАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙГ сурталчлах, ӨЛЗИЙТ НУТГИЙН урлагийн алдартнууд, өв соёлоор бахархан үзэл төлөвшүүлж, соёлын дархлааг нь дэмжиж “ӨЛЗИЙТ ӨНГӨ” хэмээх нэртэй нэвтэрхий толь бичиг бүтээх ажлыг санаачлан эхлүүлнэ. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 1.5. Иргэдийн эрх зүйн болон улс төрийн мэдлэг, соёлыг дээшлүүлж, хариуцлагатай иргэн болгож төлөвшүүлэхэд ТӨРИЙН АЛБАН хаагчдыг бодлого чиглэлээр хангаж, удирдан чиглүүлэх, төрөл бүрийн сургалтуудыг давтамжтайгаар явуулж хэвшүүлснээр тодорхой үр дүнд хүрнэ. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/

ХОЁР. Иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжиж ажиллах хүрээнд Иргэн бүрийг хамтын оролцоонд суралцуулах тэдэнд, чиглүүлэгч нь байх болно

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.1. Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаагаар Өлзийт сум өнөөгийн байдлаар тун боломжийн хандлага, харилцаатай явж ирсэн. Сумын Ахмадын зөвлөл, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Залуучуудын холбоо, Уяачдын холбоо, Нутгийн зөвлөл, Бөхийн холбоо эдгээр байгууллагуудаас гадна улсын чанартай томоохон нэгдэл, хөдөлгөөн, зөвлөл, холбоодод орон нутгийн иргэдийн оролцоог бүрэн хангуулах, иргэд оролцоотой байхын ач тусыг иргэн бүрд ойлгуулах, тэдний хүртэх үр ашиг, бүтээмж, эцсийн үр дүнд нөлөөлөхөд өөрийн оюун бодол, суртал ухуулга, сургалт сурталчилгааг өргөн хэлбэрээр зохион байгуулж мэдээ мэдээлэл, бүрийг малчин бүрийн гэрт, иргэн бүрийн санал санаачилгад хүргэхэд онцгойлон анхаарч ажиллана. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 2.2. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, 1-2 насны хүүхдийг хамруулах боломжтой болгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн журмын дагуу ахмад багш, эмч нараар болон Ахмадын зөвлөл, Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран чанартай стандарт хангасан үйлчилгээг үзүүлэхэд чиглэл зөвлөгөө, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 2.3. Төрийн байгууллагуудын ажил үйлчилгээний чанар, Төрөөс үзүүлэх бусад төрлийн үйлчилгээ / мал эмнэлэг гэх мэт / эрхэлж байгаа байгууллагад тавигдах шаардлага, стандартыг батлан, дагаж мөрдүүлэхэд хяналт тавих, үнэлгээ хийх ажлыг Иргэний нийгмийн байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг хэвшүүлнэ. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 2.4. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоог нэмэгдүүлж Ахмад, Эмэгтэйчүүдийн зөвлөлийг байнгын тогтмолжсон үйл



ажиллагаатай байлгах хөшүүрэг, механизм бий болгоно. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/

ГУРАВ. Үйлдвэрлэл хөгжүүлэх ажлын хүрээнд Өлзийт сумын нутгийн брэнд үйлдвэрлэл, Аялал жуулчлалын үйлчилгээг ахисан түвшинд хүргэнэ.


Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1. Дэлхийд танигдсан оюуны болон соёлын өвийг бүтээгч хувь хүн, баг, хамт олныг дэмжиж алдаршуулах, залгамж халааг бэлтгэхэд анхаарал хандуулж, олж тодруулах, төрөөс үзүүлэх дэмжлэгт хамруулах. Оюуны болон соёлын, биет бус өвийн бүтээлүүдийг дагасан уламжлал, ёс заншил, үндэсний онцлог бүхий брэнд үйлдвэрлэлийг хөгжүүлж экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн оролцоог бүрэн хангаж ажиллана. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 3.2. Жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгож байгаа төрийн болон сум хөгжүүлэх сангийн зээл, тусламжийн санхүүжилтийг үр ашигтай болгож, зээлдэгч бүрийг чанартай үйлдвэрлэгч байх нөхцөлийг сайтар хангах, болзол журмын дагуу иргэдийг өргөнөөр хамруулах, үр ашигтай ажиллах талаар сумын бодлого чиглэлд санал тусгуулж хэрэгжүүлнэ. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 3.3. ИНГЭНИЙ СҮҮНИЙ ФЕРМ – ҮЙЛДВЭРЛЭЛ-ийн зураг төсөв хийгдсэн, газар олголт явагдсан иргэдийн хэлэлцүүлэг хийгдсэн гэвч цаг үеийн олон улсын эдийн засгийн байдал, хорио цээрийн дэглэмээс болж саатаад байгааг анхааран ажиллаж, тууштай хөөцөлдөж үйлдвэрлэлийг бий болгоно. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 3.4. Сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа зөвшөөрөл бүхий Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, иргэн бүрд үйлчилгээний стандартуудыг мөрдүүлэх, хяналт тавих ажлыг иргэд олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулна. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 3.5. Жуулчдад зориулсан үндэсний онцлог бүхий урлаг соёлын хөтөлбөрүүд бий болгож тогтмолжуулах заалтын хүрээнд ТЭМЭЭНИЙ БАЯР арга хэмжээг тогтмолжуулах санал санаачилга гаргаж иргэдийн оролцоотойгоор зохион байгуулж хэвшүүлнэ. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/

ДӨРӨВ. Эко орчин бүрдүүлэх ажлын хүрээнд Өлзийт сумын иргэн бүр амар тайван орчин ажиллаж амьдрах нөхцөл бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.1. Сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг ландфиллын аргаар булах, хашаажуулах төслийг 2020 оны ОНХС-гийн хөрөнгөөр, батлагдсан зохих журмын дагуу үр дүнтэй гүйцэтгэх ажлыг иргэдийн оролцоо хяналттайгаар явуулна. /Хэрэгжих хугацаа: 2021- он/



- 4.2. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас бохирдсон, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг орон нутгийн иргэдийн болон албан ёсны нөхөрлөл, Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч хяналт тавина. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 4.3. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоход орон нутгийн оролцоог хангаж УУЛ УУРХАЙН ИЛ ТОД БАЙДАЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ –ийг тогтмолжуулна. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/
- 4.4. Ил тод байдал, хамтын ажиллагаанд тулгуурлан гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд, орон нутгийн оролцоотой хамтын гэрээнүүдэд /Нийгмийн хариуцлагын хүрээнд/ иргэдэд, болон орон нутагт зайлшгүй хэрэгтэй томоохон хөрөнгө оруулалтуудыг нэрчилэн тусгаж өгөхөөр САНАМЖ БИЧИГ ийг орон нутгийн удирдлагууд, гэрээнд оролцогч талуудад хүргүүлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Хэрэгжих хугацаа: 2021-2024 он/

Мөрийн хөтөлбөр боловсруулсан:

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ.....Б. ХОРЛОО

ХАЯГ: Дундговь аймгийн Өлзийт сум

ОДООГИЙН ЭРХЭЛЖ БУЙ АЛБАН ТУШААЛ: Өлзийт сумын Засаг даргын орлогч

УТАС: 88929295

РД: ЗИ 72061800

